ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2021/33/СТА-ТШЗ**


Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn
Аудитор: Л.Равдандорж
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 12

3. Аудитын тайлан ........ 14

3.1. Ерөнхий зүйл ........ 14

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 14

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 15

3.4. Материаллаг байдал ........ 15

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 15

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 16

3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 17

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17

3.9. Аудитын илрүүлэлт ........ 17

Залруулсан алдаа ........ 178

Аудитын зөвлөмж ........ 188

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 18

4. Менежментийн захидал ........ 18

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021. 02. 22 № 1-6/73

танай____________-ны №____________-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА Р.БОЛДБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

440020479

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **256868719.53** | **390313471.70** |
| **33** | **АВЛАГА** | 1,112,915.82 | 10,764,084.69 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 1,570,561.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,112,915.82 | 9,193,523.69 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,112,915.82 | 9,193,523.69 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 3,800,000.00 | 00.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 3,800,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 251,955,803.71 | 379,549,387.01 |
| **351** | **Түүхий эд материал** | 192,577,383.21 | 288,266,483.71 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 57,392,021.60 | 67,764,981.60 |
| 35130 | Эм боох материал | 135,185,361.61 | 220,501,502.11 |
| **354** | **Хангамжийн материал** | 59,378,420.50 | 91,282,903.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 174,000.00 | 20,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 52,703,985.88 | 307,547.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,476,000.00 | 1,985,960.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,309.00 | 9,309.00 |
| 35460 | Хүнсний материал | 660,985.62 | 735,259.42 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,354,140.00 | 88,224,827.88 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,462,111,120.95** | **1,969,574,149.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,462,111,120.95 | 1,969,574,149.26 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,228,074,371.09 | 1,735,574,149.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 622,451,142.03 | 622,451,142.03 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,355,971.54 | -18,200,288.42 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 208,647,037.15 | 254,447,037.15 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -39,981,259.43 | -72,547,123.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,064,046,437.49 | 1,609,624,782.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -679,813,400.01 | -769,836,640.70 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,059,445.67 | 120,731,456.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -25,937,177.03 | -33,314,987.09 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 42,588,534.66 | 42,588,534.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,630,417.90 | -20,369,763.54 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 234,036,749.86 | 234,000,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,675,000.00 | 1,675,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,638,250.14 | -1,675,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 234,000,000.00 | 234,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,718,979,840.48** | **2,359,887,620.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **113,731,412.89** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 113,731,412.89 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 113,731,412.89 |

| | | | |
|---|---|---|---|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 31,448,249.89 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 81,667,544.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 615,619.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 56,700.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 558,919.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,718,979,840.48** | **2,246,156,208.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,718,979,840.48 | 2,246,156,208.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 498,357,623.34 | 1,027,636,733.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 498,357,623.34 | 500,460,365.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 527,176,367.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 270,729,125.14 | 268,626,382.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,718,979,840.48** | **2,359,887,620.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,666,091,670.80** | **4,177,705,974.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **188,695,221.80** | **860,407,128.21** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 55,741,861.80 | 860,407,128.21 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 55,741,861.80 | 39,422,458.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,499,949.00 | 39,422,458.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,241,912.80 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 132,953,360.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 66,953,360.00 | 00.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 66,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,477,396,449.00** | **3,317,298,846.26** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,141,720,400.00 | 1,513,246,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,141,720,400.00 | 1,513,246,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 51,098,002.00 | 459,634,314.26 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 10,768,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,244,850.00 | 296,613,042.26 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 47,853,152.00 | 149,253,272.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,284,578,047.00 | 1,344,418,332.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,284,578,047.00 | 1,344,418,332.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,553,736,710.12** | **3,646,870,895.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,553,736,710.12** | **3,646,870,895.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,545,206,248.82 | 3,505,124,987.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,523,692,887.32 | 1,858,624,521.65 |
| 210101 | Үндсэн цалин | 928,162,836.27 | 997,639,955.40 |
| 210102 | Нэмэгдэл | 483,487,081.05 | 675,013,544.22 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 44,500,000.00 | 70,077,009.31 |
| 210104 | Урамшуулал | 67,542,970.00 | 115,894,012.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 198,410,693.73 | 238,956,664.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 135,843,002.91 | 169,510,564.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,640,400.00 | 17,361,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,518,490.82 | 13,889,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,128,100.00 | 7,713,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,280,700.00 | 30,481,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 131,286,539.00 | 183,492,697.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,558,189.00 | 21,758,336.94 |
| 210302 | Түлш, халаалт | 87,238,092.00 | 135,705,132.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,490,258.00 | 26,029,228.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 74,829,724.99 | 92,644,888.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,011,949.99 | 7,291,085.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,899,000.00 | 42,411,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,474,905.00 | 4,958,764.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,649,090.00 | 17,197,276.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,794,780.00 | 20,786,763.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 450,019,067.93 | 754,670,711.91 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 393,973,957.55 | 682,981,285.21 |
| 210502 | Хоол, хүнс | 52,066,045.38 | 68,952,176.70 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,979,065.00 | 2,737,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,414,520.00 | 8,305,880.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 954,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 494,820.00 | 339,880.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,919,700.00 | 7,011,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,262,550.00 | 5,269,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,262,550.00 | 5,269,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,991,999.00 | 130,412,729.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,497,050.00 | 121,291,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | 1,911,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 535,140.00 | 535,140.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,459.00 | 134,792.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 584,000.00 | 4,691,897.85 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 234,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,120,350.00 | 1,482,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,298,266.85 | 232,747,594.08 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 143,298,266.85 | 232,747,594.08 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,530,461.30 | 141,745,908.17 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,112,088.00 | 136,808,172.94 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 65,420,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,112,088.00 | 71,387,272.94 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,819.00 | 4,937,735.23 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,819.00 | 4,937,735.23 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,401,554.30 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,401,554.30 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **112,354,960.68** | **530,835,079.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,658,711.61 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,658,711.61 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,658,711.61 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **112,354,960.68** | **527,176,367.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,511,896,398.00** | **3,356,721,304.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,499,949.00** | **39,422,458.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 34,499,949.00 | 39,422,458.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 34,499,949.00 | 39,422,458.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,499,949.00 | 39,422,458.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,477,396,449.00** | **3,317,298,846.26** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,141,720,400.00 | 1,513,246,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,141,720,400.00 | 1,513,246,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 51,098,002.00 | 459,634,314.26 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 10,768,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,244,850.00 | 296,613,042.26 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 47,853,152.00 | 149,253,272.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,284,578,047.00 | 1,344,418,332.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,284,578,047.00 | 1,344,418,332.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,478,486,898.00** | **3,284,855,604.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,478,486,898.00** | **3,284,855,604.26** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,469,252,575.70** | **3,143,057,419.77** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,521,305,725.71 | 1,822,449,510.33 |
| 210101 | Үндсэн цалин | 925,775,674.66 | 961,464,944.08 |
| 210102 | Нэмэгдэл | 483,487,081.05 | 675,013,544.22 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 44,500,000.00 | 70,077,009.31 |
| 210104 | Урамшуулал | 67,542,970.00 | 115,894,012.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 198,898,005.00 | 249,309,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 136,336,505.00 | 179,863,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,640,400.00 | 17,361,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,512,300.00 | 13,889,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,128,100.00 | 7,713,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,280,700.00 | 30,481,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 131,286,539.00 | 185,423,296.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,558,189.00 | 23,688,935.94 |
| 210302 | Түлш, халаалт | 87,238,092.00 | 135,705,132.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,490,258.00 | 26,029,228.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 77,049,114.99 | 84,930,845.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,055,199.99 | 7,419,885.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,600,000.00 | 39,790,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,474,905.00 | 5,255,964.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,800,980.00 | 17,827,176.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,118,030.00 | 14,637,820.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 505,448,792.00 | 635,418,638.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 445,158,024.00 | 553,547,215.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,154,318.00 | 64,213,033.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,136,450.00 | 17,658,390.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,999,700.00 | 28,722,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 16,522,400.00 |
| 210602 | Тавилга | 3,800,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,999,700.00 | 10,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,262,550.00 | 5,269,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,262,550.00 | 5,269,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,002,149.00 | 131,533,729.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,497,050.00 | 121,357,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | 1,911,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 535,140.00 | 535,140.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,459.00 | 134,792.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,914,500.00 | 3,429,497.85 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 234,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,800,000.00 | 3,800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,234,322.30** | **141,798,184.49** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,815,949.00 | 136,808,172.94 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 65,420,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,815,949.00 | 71,387,272.94 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,819.00 | 52,276.32 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,819.00 | 52,276.32 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,401,554.30 | 4,937,735.23 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,401,554.30 | 4,937,735.23 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,409,500.00** | **71,865,700.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **33,409,500.00** | **71,865,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **33,409,500.00** | **71,865,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 33,409,500.00 | 71,865,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 33,409,500.00 | 71,865,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-33,409,500.00** | **-71,865,700.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 949,893,092.00 | 270,729,125.14 | 385,985,843.66 | 1,606,608,060.80 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **949,893,092.00** | **270,729,125.14** | **385,985,843.66** | 1,606,608,060.80 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -28,558,452.70 | -28,558,452.70 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **270,729,125.14** | **498,357,623.34** | 1,718,979,840.48 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **270,729,125.14** | **498,357,623.34** | 1,718,979,840.48 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 2,102,742.46 | 2,102,742.46 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **949,893,092.00** | **270,729,125.14** | **500,460,365.80** | 1,721,082,582.94 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -2,102,742.46 | 00.00 | -2,102,742.46 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 527,176,367.59 | 527,176,367.59 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **268,626,382.68** | **1,027,636,733.39** | 2,246,156,208.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,893,965,200.0 | 2,892,149,254.8 | 1,815,945.2 | 99.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,893,965,200.0 | 2,892,149,254.8 | 1,815,945.2 | 99.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,891,845,200.0 | 2,890,029,254.8 | 1,815,945.2 | 99.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,756,154,700.0 | 1,755,849,799.3 | 304,900.7 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 968,118,400.0 | 894,865,233.1 | 73,253,166.9 | 92.4 |
| 210102 | Нэмэгдэл | 572,360,700.0 | 675,013,544.2 | (102,652,844.2) | 117.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 73,458,000.0 | 70,077,009.3 | 3,380,990.7 | 95.4 |
| 210104 | Урамшуулал | 142,217,600.0 | 115,894,012.7 | 26,323,587.3 | 81.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 249,309,700.0 | 249,309,700.0 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 179,863,600.0 | 179,863,600.0 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,361,500.0 | 17,361,500.0 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,889,200.0 | 13,889,200.0 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,472,300.0 | 7,713,600.0 | (4,241,300.0) | 222.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,723,100.0 | 30,481,800.0 | 4,241,300.0 | 87.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 185,432,300.0 | 185,423,296.3 | 9,003.7 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32,782,900.0 | 23,688,935.9 | 9,093,964.1 | 72.3 |
| 210302 | Түлш, халаалт | 128,887,700.0 | 135,705,132.3 | (6,817,432.3) | 105.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,761,700.0 | 26,029,228.0 | (2,267,528.0) | 109.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 74,968,700.0 | 74,964,914.3 | 3,785.7 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,470,200.0 | 4,453,650.0 | 16,550.0 | 99.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,604,700.0 | 34,600,000.0 | 4,700.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,249,800.0 | 5,255,964.3 | (6,164.3) | 100.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 17,144,000.0 | 17,144,000.0 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,500,000.0 | 13,511,300.0 | (11,300.0) | 100.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 524,935,200.0 | 524,933,915.0 | 1,285.0 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 473,797,500.0 | 473,797,215.0 | 285.0 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 44,500,000.0 | 44,500,000.0 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,637,700.0 | 6,636,700.0 | 1,000.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 84,350,000.0 | 84,350,000.0 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 72,150,000.0 | 72,150,000.0 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,200,000.0 | 2,200,000.0 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.0 | 10,000,000.0 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,941,000.0 | 3,928,300.0 | 12,700.0 | 99.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,941,000.0 | 3,928,300.0 | 12,700.0 | 99.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,753,600.0 | 11,269,329.9 | 1,484,270.2 | 88.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,092,700.0 | 1,092,700.0 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,419,200.0 | 1,911,200.0 | 508,000.0 | 79.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 931,100.0 | 535,140.0 | 395,960.0 | 57.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 531,500.0 | 134,792.0 | 396,708.0 | 25.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 215,600.0 | 132,000.0 | 83,600.0 | 61.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,429,500.0 | 3,429,497.9 | 2.1 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.0 | 234,000.0 | - | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.0 | - | 100,000.0 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,800,000.0 | 3,800,000.0 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,120,000.0 | 2,120,000.0 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,120,000.0 | 2,120,000.0 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,120,000.0 | 2,120,000.0 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,893,965,200.0 | 2,897,086,990.0 | (3,121,790.0) | 100.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,513,246,200.0 | 1,513,246,200.0 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,513,246,200.0 | 1,513,246,200.0 | - | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,344,486,600.0 | 1,344,418,332.0 | 68,268.0 | 100.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,344,486,600.0 | 1,344,418,332.0 | 68,268.0 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 36,232,400.0 | 39,422,458.0 | (3,190,058.0) | 108.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 36,232,400.0 | 39,422,458.0 | (3,190,058.0) | 108.8 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **459,582,037.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **459,582,037.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 324,893,865.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 66,599,711.00 |
| 210101 | Үндсэн цалин | 66,599,711.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,295,931.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,296,235.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,190,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 683,176.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,126,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 110,484,723.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 79,750,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,713,033.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,021,690.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,908,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,908,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,341,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,341,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 120,264,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 120,264,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 134688172.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 134,688,172.94 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 65,420,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 69,267,272.94 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 459634314.26 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 459,634,314.26 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,768,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 296,613,042.26 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 149,253,272.00 |

# 3.Аудитын тайлан

## 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Р.Болдбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зохих хууль журмын дагуу зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 28-наас 2021 оны 02 дугаар сарын 03–ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 45 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын түвшинд аюулгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөс сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 2,359,887.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,598.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,276.1 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 1,112.9 | 10,764.0 | 9,651.2 |
| Урьдчилгаа | 3,800.0 | 0 | -3,800.0 |
| Бараа материал | 251,955.8 | 379,549.3 | 127,593.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,462,111.1 | 1,969,574.1 | 507,463.0 |
| **Нийт хөрөнгө** | 1,718,979.8 | 2,359,887.6 | 640,907.8 |
| Өр төлбөр | 0 | 113,731.4 | 113,731.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,718,979.4 | 2,246,156.2 | 527,176.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,718,979.8 | 2,359,887.6 | 640,907.8 |

Авлага дансны үлдэгдэл 10,764.0 мянган төгрөг болж 9,651.2 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас болон нэмэлтийн үлдэгдлээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 379,549.3 мянган төгрөг болж 127,593.5 мянган төгрөгөөр өссөн нь ковид-19 холбоотой эмийн нөөц үүсгэсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,969,574.1 мянган төгрөг болж 507,463.0 мянган төгрөгөөр өссөн нь эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин зэрэг нэмэгдсэн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвөөс 71,865.7 мянган төгрөг, хандиваар

болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 672,003.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 76,818.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 113,731.4 мянган төгрөг болж өссөн нь covid-19 өвчнөөс шалтгаалжээ.

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4,177,705.9 мянган төгрөг, өмнөх оноос 1,511,614.3 мянган төгрөгөөр буюу 36 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангийн шилжүүлэг, үйл ажиллагааны орлого зэрэгт материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь батлагдсан төсөв, төлөвлөгөө мөн тайлант онд үүссэн халдварт өвчин зэрэг нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл мянган төгрөг болж 527,176.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг, элэгдэл хорогдол шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 2,246,156.2 мянган төгрөгөөр буюу 29.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, байр ашиглалттай холбоотой зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмсэн мөн ковид-19 халдварт өвчин гарсан нь шалтгаалсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 3,356,721.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,356,721.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,893,965.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,513,246.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 36,232.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 1,344,486.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,513,246.2 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,344,418.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 39,422.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 2,897,087.0 мянган төгрөгийг зарцуулж 3,190,1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,892,149.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 3,000.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргаас 10,768.0 мянга төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 296,613.0 мянга төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 149,253.2 мянган төгрөг, нийт 459,634.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин-д 66,599.7 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 10,295.9 мянга төгрөг, норматив зардалд 110,484.7 мянган төгрөг, эд хогшил худалдаг авахад 15,908.1 мянган төгрөг, томилолтын зардалд 1,341.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 120,264.4 мянга төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 134,688.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 52.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл, мэдээлэлгүй 3 байна.

## 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 172.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 172.1 | 2 | 172.1 | | | |
| Нийт дүн | | | | | | | |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 283,721.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 283,121.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 600.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн ЭМГ-аас тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 24,765.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор тусгуулж залруулсан.
2. Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй 8 нэр төрлийн 114,191.7 мянган төгрөгийн хөрөнгөнд ашиглах жил, элэгдлийг оруулан залруулсан.

3. Үр дүнгийн тайланд зардлын зориулалтыг буруу тайлагнасан 143,936.3 мянган төгрөгийн илэрхийллийг залруулсан.
4. Ажиллагсад болон, харилцагч байгууллагатай үүссэн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй 227.9 мянган төгрөгөөр зөрүүлэн бүртгэсэн байсныг залруулсан.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 600.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн ЭМГ болон бусад дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр хөрөнгө ирүүлдэг боловч тооцоо нийлж баталгаажуулж ажиллахгүй байгаа тул хөрөнгийн бүртгэл, хадгалалт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Хөрөнгийн данстай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт: Бусад хангамжийн материал, тусгай зориулалтын материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг авсан мөн материалыг тоо хэмжээгээр нь бүртгэж аваагүй, үндсэн хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл аваагүй зэрэг зөрчил байна.*

*1.2.* *Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хөрөнгө алдагдах, бодит зарцуулалтыг тооцож ажиллах боломжгүй байдал үүсэхээр байна.*

*1.3.* *Өгсөн зөвлөмж:Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 8-д “төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:”1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол 7 дугаар зүйл “хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.5 “хэмжигдэхүйц байх” гэж тус тус заасан байдаг тул үндсэн хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл, байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, төсвийн зарцуулалтын үр ашиг зэргийг сайжруулж зохих ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулж ажиллах.*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

2.1. *Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн орлого, санхүүжилт зэргийг зарцуулахдаа холбогдох дүрэм журмыг баримтлаагүй байна.*

2.2. *Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, тогтоомжийг зөрчих.*

2.3. *Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 47 дугаар зүйл 47.1-т "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно" Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-д тус тус заасан тул үйл ажиллагаанаас олох орлогыг үндсэн дансаар дамжуулан зохих журмын дагуу зөвшөөлөө авч, тушаал шийдвэрээр зарцуулах.*

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

*Зардлын данстай холбоотой асуудал*

3.1 *Илрүүлэлт: ЭМЯ-аас цалингийн өглөгт өгсөн дэмжлэгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд эрх нээлгүүлэхдээ зохих эдийн засгийн ангилалд тавиулаагүй тэтгэмж урамшууллаас зарцуулсан байна.*

3.2 *Эрсдэл*: Батлагдсан эх үүсвэрийг *зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, тогтоомжийг зөрчих.*

3.3 *Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 47 дугаар зүйл 47.1-т "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно" Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал"-д тус тус заасан тул хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн зардлын эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, зарцуулах.*

3.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

*Зардлын данстай холбоотой асуудал*

4.1 *Илрүүлэлт: Байгууллагын даргын 2020 оны А/27 дугаар тушаалаар ажилчдад олгогдсон 6,000.0 мянган төгрөгийн урамшууллаас ХХОАТ суутгаж тайлагнаагүй байна.*

4.2 *Эрсдэл*: Татварын хууль тогтоомжийг зөрчих.

4.3 *Монгол Улсын Татварын ерөнхий хууль 6 дугаар зүйл 6.1.19.“суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг; 28 дугаар зүйл 28.7.Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана. 83 дугаар зүйл 83.1.Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй. гэж тус тус заасан байдаг тул цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж татвар, хураамжийг суутган, тайлагнаж байх.*

4.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021

Аудитын нэр: ***2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: дга-2021/33/ста-тшз

Шалгагдсан байгууллагын нэр: Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Бусад хангамжийн материал, тусгай зориулалтын материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг авсан мөн материалыг тоо хэмжээгээр нь орлогодоогүй. | 0.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 2 | Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн орлого, санхүүжилт зэргийг зарцуулахдаа холбогдох дүрэм журмыг баримтлаагүй байна. | 0.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 3 | ЭМЯ-аас цалингийн өглөгт өгсөн дэмжлэгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд эрх нээлгүүлэхдээ зохих эдийн засгийн ангилалд тавиулаагүй тэтгэмж урамшууллаас зарцуулсан байна | 0.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 4 | Байгууллагын даргын 2020 оны А/27 дугаар тушаалаар ажилчдад олгогдсон 6,000.0 мянган төгрөгийн урамшууллаас ХХОАТ суутгаж тайлагнаагүй байна. | 600.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 5 | Үйл ажиллагааны орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох зөвшөөрөл аваагүй. | 0.0 | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 6 | Аймгийн ЭМГ-аас тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг орлогоор аваагүй. | 24,765.3 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 7 | Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй 8 нэр төрлийн хөрөнгөнд ашиглах жил, элэгдлийг оруулаагүй. | 114,191.7 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 8 | Үр дүнгийн тайлан буруу тайлагнасан. | 143,936.3 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| 9 | Ажиллагсад болон, харилцагч байгууллагатай үүссэн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. | 227.9 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | Р.Болдбаатар, Т.Ганчимэг |
| **ДҮН** | | **283,721.2** | | | |